



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН
ШИНЭЧЛЭЛ-2022 ОН**

2021.08.14

БОДЛОГО



Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030

Алсын хараа-2050

Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030



Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалтад хүрэх

Хэнийг ч орхигдуулахгүй байх



Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Төрөөс эрүүл мэндийн талаарх баримтлах бодлогыг хэрэгжүүлэх

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө

ЗАРЧИМ



Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх



Иргэнээ эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдлээс хамгаалах

2022 ОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн шинэчлэлийг боловсронгуй болгож, сайжруулна.



2. Анхан шатлалын тусламж, үйлчилгээг бэхжүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ.



3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүл мэндийн Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх шалгуур үзүүлэлтийг дээшлүүлнэ.



4. Эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд үндэслэн тухайн байгууллагын үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5. Коронавируст халдварын эрсдэлээс сэргийлэх, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангаж ажиллана.




6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн аргыг гүйцэтгэл, үр ашигт суурилсан Оношийн хамааралтай бүлгийн санхүүжилтийн аргад шилжүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг нэмэгдүүлнэ.




1. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ҮНДЭСНИЙ ТООЦОО БА ТӨСӨВ

2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлээр эрүүл мэндийн салбарт зарцуулсан зардал нь ДНБ-д эзлэх эрүүл мэндийн зардлын 2.4 хувь, Засгийн газрын төсвийн зардал 7.0 хувьтай тэнцэж байна.

Зураг 1. ДНБ-д эзлэх эрүүл мэндийн салбарын төсвийн хувь хэмжээ



Зураг 2. Засгийн газрын нийт зардалд эзлэх эрүүл мэндийн салбарын төсвийн хувь



Төрөөс Эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод Улсын нэгдсэн төсвөөс эрүүл мэндийн салбарт зарцуулах зардлыг 12 хувьд хүргэх, ДНБ-ний 5-аас доошгүй хувьд хүргэх зорилтыг тусгасан.

Дээрх бодлого, хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээнд үе шаттайгаар хүрэхийн тулд Эрүүл мэндийн салбарын төсвийг 2022 онд Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, ДНБ-ний өсөлтийн хэмжээ, улсын эдийн засаг, нийгмийн төлөв байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэл, ЭМДС-ын 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, гүйцэтгэлийн санхүүжилтийн хэрэгжилт, үр дүнд үндэслэн ДНБ-д эзлэх хувь 4.5, Нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь 13.2 хувь байхаар тооцон боловсрууллаа.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн салбарын 2022 оны төсвийн төсөл

/тэрбум.төг/

Эдийн засгийн ангилал	2021 оны батлагдсан	2022 оны төсвийн төсөл	Зөрүү
НИЙТ	742.8	1,942.1	1,199.3
УРСГАЛ ЗАРДАЛ	661.3	1,249.4	588.1
Улсын төсвөөс олгох тусламж үйлчилгээний санхүүжилт	496.4	951.2	454.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20.3	24.5	4.2
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21.5	20.9	-0.6
Резидент эмч нарын цалин	18.5	24.9	6.4
Бусад	104.6	227.9	123.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	81.5	692.7	611.2
Барилга байгууламж	59.9	202.1	142.2
Их засвар	8.9	189.4	180.5
Тоног төхөөрөмж	12.6	301.1	288.5

2022 ОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦЫН УРСГАЛ ТӨСӨВ

Эрүүл мэндийн сайдын багцын нийт урсгал зардлыг 2022 онд **1,249.4** тэрбум төгрөгөөр буюу 2021 оны батлагдсан төсвөөс **588.1** тэрбум төгрөгөөр давуулан төлөвлөв.



Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн шинэчлэлийн арга хэмжээг сайжруулж, боловсронгуй болгоно.

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасан төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан төсвийн хэрэгцээг тооцож шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлэхээр төлөвлөв.

Хүснэгт 2. Тусламж, үйлчилгээний Нэмэгдэх санхүүжилт

АРГА ХЭМЖЭЭ		Дүн /мян.төг/
Нийт нэмэлт шаардлагатай зардал		454,798.6
1	Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний зардал	125,192.19
1.1	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	15,542.76
1.2	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	68,745.70
1.3	Оношилгоо, шинжилгээ/ Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ	582.64
1.4	Яаралтай тусламж	29,324.54
1.5	Хорт хавдрын химийн болон туяа эмчилгээний эмчилгээ	10,996.55
2	Бусад яамны харъяа эрүүл мэндийн байгууллагын зардал	11,535.03
3	Хувийн эмнэлгээр үйлчлүүлэх даатгуулагчийн зардал	66,353.45
3.1	Хувийн хэвшлийн эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардал	54,524.14
3.2	Хувийн хэвшлийн эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний зардал	11,829.31
4	Анхан шатлалын тусламж, үйлчилгээний зардал	2,592.1
5	Эмийн хөнгөлөлтийн зардал	14,824.20
5.1	Төрөөс төлбөрийг хариуцах эмийн зардал	14,824.20
6	Засгийн газрын хөтөлбөр арга хэмжээний зардал	23,574.80
6.1	"Эрүүл шүд- Эрүүл хүүхэд" хөтөлбөр	23,574.80
7	Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээ	210,726.70

7.1	Хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ	13,226.70
7.2	ПГУ шинжилгээ	97,500.00

Санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд 2021 онд төсөвт тусгагдаагүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт

1. Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн зардал

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.7-д заасан “удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал”-ыг төр хариуцахаар баталсан бөгөөд энэхүү эмийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 129/100 дугаар тушаалаар “Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам”-ын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч өнөөдрийн байдлаар тус эм олголтын хэрэгжилтийн хувь дунджаар 49.9 хувь байна. Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж буй санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд 2021 оны төсөвт үнэ, төлбөргүй олгох эмийн төсөв тусгагдаагүй тул суурь төсвөөр дутуу санхүүжүүлж байгаа тул 2022 онд бүрэн олгох санхүүжилтийг тооцож тусгалаа.

ЭМД-ын сангаас зарцуулж буй төсөв: 5.0 тэрбум төгрөг

Хяналтын өвчтөнөөс эм ууж буй хүний дундаж хувь: 49.9%

Нэмэлт шаардлагатай: 14.8 тэрбум төгрөг

№	Өвчин эмгэг	Хувь
1	Сүрьеэ /A15-A18/	0
2	Хорт хавдрын 3.4-р үе	51.6
3	Сэтгэцийн эмгэг	28.5
4	Чихрийн шижин	66.0
5	Чихрийн бус шижин /E11/	85.0
6	Бамбай булчирхайн дутмагшил /E01-03/	73.8
7	Өнчин тархины шалтгаант өсөлтийн дааварын дутмагшил /E23/	65.4
8	Паркинсоны өвчин /G20/	39.6
9	Уналт таталт (Эпилепси) /G40-G41/	66.2
10	Миастени /G70/	54.3
11	Нүдний даралт ихсэх өвчин (Глаукома) /H40-H42/	59.2
12	Эрхтэн шилжүүлж суулгасны дараах байдал	37.5
13	Дархлалын олдмол хомсдол өвчин	0
14	Гемофилий /D65-69/	51.5
Нийт дүн		49.9

2. Жирэмсний хяналтын багц

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.1-д заасан “жирэмсэн, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардал”-ыг төр хариуцахаар баталсан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолд Эрүүл мэндийн сайдын 318 тоот тушаалын дагуу хэвийн болон эрсдэлтэй жирэмсэнд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж үйлчилгээг багц болгон оруулж баталсан. 2021 оны төсөвт тус тусламж, үйлчилгээний төсвийг Эрүүл мэндийн даатгалын санд санхүүжүүлээгүй бөгөөд тус зардлыг төрөөс бүрэн санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийг тооцож тусгасан.

Жилд дунджаар жирэмсэний хяналтанд: 78,000 эмэгтэй

Нэмэлт шаардлагатай: 68.5 тэрбум төгрөг

Жирэмсний хяналтын хугацаанд хийгдэх, үзлэг, оношлогоо, шинжилгээний тариф

Жирэмсний хугацаанд хийгдэх үзлэг, оношлогоо, шинжилгээ		тариф
Үзлэг	Эх барих эмчийн үзлэг	20,000
Шинжилгээ	Жирэмсний сорил	2,000
	Цусны ерөнхий шинжилгээ	10,000
	Цусны бүлэг	10,000
	Резус бүлэг тодорхойлох	10,000
	ХДХВ-ийн эсрэг бие илрүүлэх хурдавчилсан арга	5,000
	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан арга	5,000
	Элэгний В,С вирус илрүүлэх	5,000
	Шээсний ерөнхий шинжилгээ	10,000
	Шээсэнд нян илрүүлэх	5,000
	Тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээ	10,000
	ХДХВ-ийн эсрэг бие илрүүлэх шинжилгээ	10,000
	Үтрээ, умайн хүзүүний наацын шинжилгээ	15,000
	В бүлгийн стрептококк илрүүлэх шинжилгээ	35,000
	Биохимийн шинжилгээ	15,000
	Умайн хүзүүний эсийн шинжилгээ	20,000
	"ToRCH" халдварыг илрүүлэх	75,000
	Пренатал илрүүлэг	20,000
Оношилгоо	Сүрьеэ илрүүлэх (асуумж)	10,000
	Рентген	15,000
	Хэт авиа	35,000

Товлол	Жирэмсний хугацаа	Тариф
1	12 долоо хоног дотор	127,000

2	18-22 долоо хоног	55,000
3	28 долоо хоног	40,000
4	32 долоо хоног	100,000
5	38 долоо хоног	20,000
Эрүүл жирэмсний хяналтын өртөг		342,000
1	12 долоо хоног дотор	297,000
2	18-22 долоо хоног	55,000
3	28 долоо хоног	45,000
4	32 долоо хоног	115,000
5	38 долоо хоног	30,000
6	39-40 долоо хоног	30,000
Эрсдэлтэй жирэмсний хяналт		572,000

3. Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10-д заасан “эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ”-ний зардлыг төр хариуцахаар баталсан бөгөөд Эрүүл мэндийн сайдын А/293 тушаалаар баталсан журмын дагуу эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг үзүүлдэг. 2020 оны байдлаар улсын хэмжээнд эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээнд 825,220 иргэн хамрагдсан ба үүний 25-30% гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээг авсан байна. Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээний өртөг, зардлыг тооцож үзэхэд ялгаатай байсан тул ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолд яаралтай тусламж, үйлчилгээг ерөнхий болон гэмтлийн гэсэн 2 ангиллаар батлуулж хэрэгжүүлж эхэлсэн тул гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээний зардлыг тооцоолж нэмэгдэх зардлыг тусгасан.

Гэмтлийн яаралтай тусламжийн тохиолдлын тоо: 195992

Нэмэлт шаардлагатай төсөв: 29.3 тэрбум төгрөг.

№	Өвчлөлийн төрөл	Тохиолдлын тоо
1	Зүрх судас	90,701
2	Мэдрэл	58,345
3	Хоол боловсруулах замын	136,085
4	Шээс бэлгийн замын	34,699
5	Арьсны замын өвчин	54,971
6	Мэс засал	46,023
7	Осол гэмтэл	149,969
8	Архины хордлого	13,108
9	Цус төлжүүлэх эрхтний	8,376
10	Дотоод шүүрлийн тогтолцоо	17,024
11	Эх барих эмэгтэйчүүд	152,192

12	Сэтгэцийн өвчин	6,356
13	Хавдар	5,663
14	Халдварт өвчин	15,647
Үүнээс Гэмтлийн шалтгаант		195,992

4. Хорт хавдрын бай эмчилгээ

Хорт хавдрын тусламж, үйлчилгээг өргөжүүлж химийн эмчилгээний нэр төрлийг бай эмчилгээгээр нэмэгдүүлсэнтэй холбоотой тооцоололыг 2022 оны төсөвт тусгасан.

Бай эмчилгээнд хамрагдах хүний тоо: 350

Нэмэлт шаардлагатай төсөв: 10.9 тэрбум төгрөг.

Зонхилон хэрэглэх бай эмчилгээний төсвийн тооцоолол:

№	Нэршил	Хорт хавдрын төрөл	Өвчтөн	Давтамж	Хэрэгцээ	Өртөг (төг)	Нийт төсөв
1	Трастузумаб	Хөхний хорт хавдар, Ходоодны хорт хавдар	62	18	1116	1,843.8	2,657,681
2	Бевацизумаб	Бүдүүн, шулуун гэдэсний үсэрхийлсэн хавдар, Хожуу үеийн хөхний хорт хавдар, Өндгөвчний хорт хавдар, Умайн хүзүүний хорт хавдар	86	6	516	3,200.0	1,651,200
3	Gifitinib	Жижиг эсийн бус уушигны хорт хавдар	69	6	414	5,000.0	2,070,000
4	Dabrafenib / trametinib	Меланома хавдар,	5	6	30	8,000.0	240,000
5	Lapatinib	Хөхний хорт хавдар, Ходоодны хорт хавдар	28	6	168	5,500.0	924,000
6	Sorafenib	Элэгний хорт хавдар	96	6	576	6,000.0	3,456,000
Нийт							10,998,881

5. Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний санхүүжилт

Төрөөс эрүүл мэндийн талаарх баримтлах бодлогод тусгасан төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн ялгаатай байдлыг арилгах зорилтын хүрээнд ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор суурь тарифыг ижил болгож баталснаар хувийн хэвшлийн эмнэлгүүд төр хариуцдаг байсан тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрэн бүрдсэн. 2021 онд Эрүүл мэндийн даатгалын хуулинд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг эрхзүйн баримт бичгүүдэд тусгах ажлуудыг үе шаттайгээр хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудыг сонгох сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэх ажил хийгдэж байгаа тул 2020 оны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээг түр сунган санхүүжүүлж байна.

Нэмэлт шаардлагатай санхүүжилт: 54.5 тэрбум төгрөг

Мөн Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хуулиудад заасны дагуу Клиник эмнэлэг буюу амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй үүдэн эмнэлгүүдийн амбулаторийн тусламж үйлчилгээний санхүүжилтыг 11.8 тэрбум төгрөгийг тооцож тусгасан. Энэхүү тооцоололд амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй шүдний эмнэлгүүдийг хасаж тооцсон болно.

Нэмэлт шаардлагатай санхүүжилт: 11.8 тэрбум төгрөг

6. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цогц тусламж үйлчилгээг санхүүжүүлэх

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268 тушаалаар Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цогц тусламж үйлчилгээг санхүүжүүлэх журмыг батлан гаргаж 2021 оны 3 сарын 1-нээс хэрэгжүүлсэн бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 5 төрлийн тусламж, үйлчилгээнд 260.2 тэрбум төгрөгний зардал гаргахаар байна. 2022 онд хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ болон шинжилгээний зардал байхаар тусгасан.

Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээ		2021 оны төсөв		2022 оны төсвийн төсөл	
		Батлагдсан төсөв	ХБГ	Төлөвлөгөө	Зөрүү
		0.00	260,194.56	210,726.70	210,726.70
1	Хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ	0.00	113,226.70	113,226.70	113,226.70
2	Дархлаажуулалтын үйл ажиллагааны зардал	0.00	34,475.93	0.00	-
3	ПГУ шинжилгээ	0.00	97,500.00	97,500.00	97,500.00

4	ПГУ шинжилгээний сорьц цуглуулах үйл ажиллагааны зардал	0.00	9,750.00	0.00	-
5	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	0.00	5,241.92	0.00	-

7. Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулэн Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу бүх нэгдсэн эмнэлэг болон төрөлжсэн эмнэлгүүдийг хагас бие даасан тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.



Эмийн чанар аюулгүй байдалд хяналт тавьж, эмийн үнийг олон улсын жишигтэй уялдуулан тогтооно.

1. Монгол улсад шинээр үйлдвэрлэж байгаа болон гадаад зах зээлээс худалдан авч буй эмийн чанар, аюулгүй байдалд хяналт шалгалт, тандалт судалгаа хийх, монгол улсад бүртгэх, дүгнэлт гаргах зорилгоор Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын харьяанд Эмийн хяналтын лабораторийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас шилжүүлэн авахаар тооцож орон тоо, урсгал төсвийг нэмэгдүүлэн тусгав.

Орон тоо: 52

Нийт урсгал төсөв: 1.2 тэрбум төгрөг

2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үндэсний хэмжээнд цогц байдлаар хөгжүүлэх, сэргийлж болох өвчин эмгэгийн тархалт, өвчлөлийг бууруулах зорилгоор Биобэлдмэлийн үйлдвэрийг тус төвийн харьяад үйл ажиллагааг нь эхлүүл хөгжүүлэхэд шаардлагатай урсгал зардлыг нэмэгдүүлэн төлөвлөсөн.

Орон тоо: 37 орон тоо

Нийт урсгал зардал: 606.3 сая төгрөг

3. Эрүүл мэндийн салбарын цахим мэдээллийн тогтолцооны тогтвортой байдал, тасралтгүй хөгжлийн хангах зорилгоор Эрүүл мэндийн мэдээлэл, технологийн үндэсний төвийг байгуулах урсгал зардлыг тооцож тусгав.

Орон тоо: 44 орон тоо

Нийт урсгал зардал: 4.5 тэрбум төгрөг



Коронавируст халдварын эрсдэлээс сэргийлж, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангаж ажиллана.

1. Коронавируст халдварын эрсдэл, хүндрэлээс сэргийлэх зорилгоор томуугийн эсрэг вакцинд зорилтот насны хүн ам болон сургуулийн насны хүүхдийг хамруулахаар тооцож төлөвлөсөн.

Тоо хэмжээ: 550000 хүн/тун

Нийт урсгал төсөв: 6.3 тэрүм төгрөг

2. 0-11 насны хүүхдийг Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад хамруулахаар тооцож 4.5 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэн тусгасан.

Тоо хэмжээ: 895923 хүн/тун

Нийт урсгал төсөв: 45.1 тэрүм төгрөг

3. 0-2 насны бүх хүүхдийг уушгины хатгааны эсрэг вакцинд бүрэн хамруулахад 3.7 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд 2022 онд нэмэлт шаардлагатай төсвийг тооцож тусгалаа.

Тоо хэмжээ: 299637 хүн/тун

Нийт урсгал төсөв: 1.3 тэрүм төгрөг

4. Коронавируст халдварын болзошгүй эрсдэл, хүндрэлээс сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор шаардлагатай нөөц бүрдүүлэхээр тооцож холбогдох зардлыг төлөвлөсөн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц: 30.0 тэрбум төгрөг

Цалин, НДШ: 9.1 тэрбум төгрөг



Анхан шатлалын тусламж, үйлчилгээг бэхжүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ.

1. Анхан шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж буй Өрхийн эрүүл мэндийн төв болон Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн суурь тусламж, үйлчилгээний нэг иргэнээр тооцсон тарифын ялгааг 2020 оноос арилгасан ба дундаж хэмжээг 30.0 мянган төгрөгт хүргэж ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоолын дагуу санхүүжүүлж байна. Үүний дагуу нэг иргэнд ногдох зардлыг хүн амын өсөлтөөр тооцож 1.1 тэрбум төгрөг, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож 1.2 тэрбум төгрөг, нийт 2.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүл мэндийн Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх шалгуур үзүүлэлтийг дээшлүүлнэ.

1. “Эрүүл шүд - Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2021 онд нийт 392 мянган хүүхдийг хамруулахаар тооцож 23.5 тэрбум төгрөгийг төлөвлөсөн ба 2021 он төсөв батлагдаагүй тул хэрэгжээгүй.
2. Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан улсын төсвөөс санхүүжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зардлыг тусгасан. Үүнд:
 - Хавдрын эсрэг арга хэмжээ 1.6 тэрбум төгрөг
 - Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ 1.5 тэрбум төгрөг
 - Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээ 0.5 тэрбум төгрөг
 - Эрүүл идэвхитэй амьдрал арга хэмжээ 0.5 тэрбум төгрөг
 - Харшлаас сэргийлэх арга хэмжээ 0.2 тэрбум төгрөг
3. Эрүүл мэндийн дэмжих сангийн төсвийг тусгай сангийн бүрдүүлэх орлогын эх үүсвэртэй уялдуулан 2020 оноос 2.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 5.0 тэрбум

төгрөг байхаар төлөвлөж Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 218 дугаар зүйлийн 218.2, 218.3, 218.4-д заасан арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар тусгалаа.



Эрүүл мэндийн салбарын ажилчдын тэтгэмж, урамшууллыг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг дээшлүүлнэ.

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор 2021 оноос резидент эмчийг цалинжуулж эхэлсэн бөгөөд 2020-2021 онд элсэн суралцаж буй болог 2022 онд шинээр элсэн суралцах резидент эмч нарын цалингийн зардлыг тусгасан. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяанд элсэн суралцаж буй 707 резидент эмчийн цалингийн зардлын нэмэгдүүлэн төлөвлөв.

2020-2021 онд суралцаж байгаа 1889 резидент

2022 онд шинээр элсэн суралцах 800 резидент

нийт зардал: 24.9 тэрбум төгрөг .

2. Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрүүл мэндийн ажилтнуудад нэг удаагийн тэтгэмжийн зардлыг тооцож тусгасан.

Хүний тоо: 1121 эрүүл мэндийн ажилтан

Нийт зардал: 24.5 тэрбум төгрөг

3. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийн хамрах хүрээг нэмэгдүүлж, төсвийг тооцсон.

Хүний тоо: 4558 эмнэлгийн мэргэжилтэн

Нийт зардал: 20.9 тэрбум төгрөг

4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхижуулах зорилтын хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн чиглэл, гадаад сургалт, багц цагийн сургалтанд хамруулахаар зардлыг тооцон тусгасан.

Хүний тоо: 5200 эмнэлгийн мэргэжилтэн /давхардсан тоогоор/

Нийт зардал: 3.1 тэрбум төгрөг

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦЫН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн Эрүүл мэндийн сайдын багцын хөрөнгө оруулалтын санал нийт **971.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 692.0 тэрбум төгрөгийн** санхүүжих дүнтэй **816** төсөл арга, хэмжээ нэгтгэгдсэн.Үүнд:

- Барилгын хөрөнгө оруулалтад нийт **132** төсөл арга хэмжээний **479.5** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **202.1** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэйгээр санал нэгтгэгдсэн бөгөөд үүнээс Шилжих барилга **38** төсөл арга, хэмжээний **171.0** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **59.2** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэйгээр, Шинэ барилга **94** төсөл арга, хэмжээний **308.5** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **142.0** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэйгээр нэгтгэгдсэн.
- Их засвар /Улсын хэмжээнд/-ын хөрөнгө оруулалтад нийт **182** төсөл, арга хэмжээний **189.4** тэрбум төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэйгээр нэгтгэгдсэн.
- Тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийн хөрөнгө оруулалтад нийт **502** төсөл арга, хэмжээний **302.3** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **301.0** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэйгээр нэгтгэгдсэнээс Шилжих тоног төхөөрөмжид **5** төсөл арга, хэмжээний **3.1** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **1.8** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэйгээр, Шинэ тоног төхөөрөмжид **497** төсөл арга, хэмжээний **299.1** тэрбум төгрөгийн төсөвт, санхүүжих дүнтэйгээр нэгтгэгдсэн.

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын I үе шат болох Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх “Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техникийн технологийн дэвшилийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтоолцоог бүрдүүлэх” арга хэмжээний суурь бэлтгэлийг хангах, үе шаттай хэрэгжүүлэхийн тулд шинээр **125** төсөл, арга хэмжээний **450.3** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **380.1** тэрбум төгрөгийн санхүүжилт зайлшгүй шаардлагатай гэж эрэмбэлсэн болно.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн Эрүүл мэндийн сайдын багцын барилга байгууламжийн саналд нийт **479.5** тэрбум төсөвт өртөгтэй **202.1** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй нийт **83** барилга байгууламжийн саналыг нэгтгэн боловсруулаад байна. Үүнд:

1. Шилжих **38** барилга байгууламжийн **171.0** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **59.2** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй бөгөөд **1 барилга** байгууламж нь төсөвт өртөгийг нэмэгдүүлэхээр.
2. Шинээр **94** барилга байгууламжийн **308.5** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **142.9** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй саналыг <https://publicinvestment.gov.mn/> цахим системээр эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн. **Үүнээс:** Сангийн яамны нэгдсэн <https://publicinvestment.gov.mn/> цахим системээр Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэгт Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор, мөн хуулийн 29.4. **Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэж зааснб дагуу** Сангийн сайдын 2019 оны 282 дугаар журмын дагуу ирүүлсэн саналуудыг **шаардлагад нийцсэн иж бүрдэл бүрэн барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулсан зурагтай төсөвтэй** байх зэрэг үндсэн шалгууруудаас зөвхөн **45 барилга байгууламжийн 200.5** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **130.3** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй ажлуудыг **нэн шаардлагатай** хэмээн эрэмбэлсэн болно.

Эрүүл мэндийн салбарт удаан хугацаанд хэрэгжиж байгаа боловч ашиглалтад ороогүй төсөвт өртгийн нэмэгдэлийг жил бүр Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг боловч төсөвт өртөг нэмэгдэж батлагдагүй Геронтологийн төвийн барилгын төсөвт өртгийг 7,392 тэрбум төгрөгөөс 17,600 тэрбум төгрөг болгож өсгөн тухайн барилгын байнгын ашиглалтад оруулж Ахмад настануудын сувлин асрах төвтэй болох асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай байна.

Дээрх 45 шинэ барилгын зураг төсөв хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөв болон газрын зөвшөөрөл хангагч байгууллагуудын техникийн нөхцөлүүдийг авсан бөгөөд Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгагсан тохиолдолд аймаг, нийслэл, сумын эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний чадавхи нэмэгдэх юм.

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн Эрүүл мэндийн сайдын багцын хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмжийн саналд нийт **302.3** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, **301.0** тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй хөрөнгө оруулалтыг саналыг тусгасан. Үүнд:

1. Шилжих тоног төхөөрөмж: Нийт **5** төсөл, арга хэмжээний **3.1** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд үлдэгдэл санхүүжилт **1.8** тэрбум төгрөгийг тусгалаа.
2. Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай автомашины парк шинэчлэлтэд **2.5** тэрбум төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэйгээр санал нэгтгэсэн. Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-үүдэд, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад түргэн тусламжийн автомашин /фургон, хантер/-аар хангахаар,
3. Алсын Хараа 2050 -д тусгагдсан “Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн санг бүрдүүлэх” зорилтын хүрээнд **9.0** тэрбум төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэйгээр компьютер худалдан авч бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудыг хангахаар,
4. Бүх шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор, ковидын дараах эмнэлгийн тусламж үйлчилгээ, нөхөн сэргээх эмчилгээнд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авахад нийт **30.0** тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгааг тусгасан болно. Тухайлбал Мэс заслын С-арм рентген аппарат, оношилгооны болон мэс заслын дурангийн иж бүрдэл, хавдар, урологийн болон нээлттэй мэс заслын багажны шинэчлэл, физик эмчилгээ, нөхөн сэргээх эмчилгээний тоног төхөөрөмжүүдийн хангалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөөд байна.
5. УИХ-ын гишүүдээс тойргийн болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж, автомашины хөрөнгө оруулалтын саналыг нэгтгэн **59** төсөл, арга хэмжээний **30.8** тэрбум төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэйгээр уламжилсан бөгөөд тус саналд шинээр ашиглалтад орж эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэхэд илүүтэйгээр санал боловсруулагдсан бол,
6. Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилттэй холбогдуулан төрөлжсөн болон нарийн мэргэжлийн төв, улсын нэгдсэн эмнэлэг, Нийслэлийн клиникийн нарийн мэргэжлийн 14 төв, дүүргийн эрүүл мэндийн 9 нэгдэл, дүүргийн нэгдсэн 4 эмнэлэг, амаржих газар 3 зэрэг эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хийхэд шаардлагатай **95.4** тэрбум төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэйгээр тус тус нэн шаардлагатай гэж эрэмблэн төсвийн төсөлд тусган нэгтгэлээ.

ИХ ЗАСВАР

Эрүүл мэндийн байгууллагуудаас их засвар хийлгэхээр нийт 31 эрүүл мэндийн байгууллагын **182** төсөл, арга хэмжээний **189.4** тэрбум төгрөгийн санал ирүүлсэн.

№	Аймаг, нийслэл, харьяа эрүүл мэндийн байгууллага	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг
1	Харьяа байгуулга	67	39,316.1
2	Аймаг	106	50,474.8
3	Дүүргийн эрүүл мэндийн төв	9	99,644.1
	НИЙТ	182	189,435.0

Үүнээс:

- 1. 9.5** тэрбум төгрөгийн **30** төсөл, арга хэмжээ нь **Төсвийн тухай хуулийн заалтыг хангасан** буюу зураг, төсөв батлагдсан. **СЭМҮТ, ХӨСҮТ, 8 аймгийн эрүүл мэндийн байгууллага,**
- Мэс заслын тасаг олон улсын стандартад нийцсэн бүрэн вакум хагалгааны өрөөнүүдтэй болсноор мэс заслын дараах шархны халдвар эрс багасах, өвчтөний аюулгүйн байдлыг хангах,
- Хэдийгээр үлдсэн ажлууд зураг, төсөв батлагдаагүй ч Эрүүл мэндийн байгууллагуудын ихэнх барилга байгууламж нь олон жил их засвар хийгдээгүй улмаас дээврээс ус гоожиж хана, таазанд нуралт үүссэн, мөөгөнцөртсөн, сантехник, халаалтын систем доголдолтой зэрэг шалтгааны улмаас нийт ирүүлсэн саналаас нэн шаардлагатай **51** төсөл, арга хэмжээ буюу **85.2** тэрбум төгрөгийн засвар хийлгэх хөрөнгийг тусгах зайлшгүй шаардлагатай байна.



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**



ЭМД
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

СТРАТЕГИЙН ХУДАЛДАН АВАЛТ -2022 ОН

2021.08.14

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ

1.1 Хууль эрх зүйн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал

Эрүүл мэндийн даатгалын тухай, Төсвийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эмнэлгийн тусламжийн тухай хуулиуд, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын тогтоолууд, Монгол Улсын Засгийн Газрын тогтоол, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолууд, Эрүүл мэндийн сайдын тушаалууд болон бусад холбогдох хууль, эрх зүйн актуудыг үндэслэл болгон төсвийн төслийг боловсруулав. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд батлагдсан гол эрхзүйн баримт болох Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03, 04 дүгээр тогтоолыг үндэслэл болгон төсвийн тооцооллыг хийсэн.

1.2 2022 онд баримтлах төсвийн бодлого

1.2.1 Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллана.

- ✓ Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий Газар нь стратегийн худалдан авагчийн хувьд гэрээт эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоно
- ✓ Гэрээт эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлага, санхүүгийн удирдлага, чанарын удирдлагын тогтолцоог сайжруулахад удирдлага, аргазүйн дэмжлэг үзүүлнэ
- ✓ Үр ашиг бага шаардлагагүй хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ, давхардсан оношлогоо, шинжилгээг бууруулна
- ✓ Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ
- ✓ Сангийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана
- ✓ Тусламж, үйлчилгээний үнэ тогтоох үйл явцыг өртгийн тооцоонд үндэслэн хэрэгжүүлнэ

1.2.2 Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлнэ

- ✓ **Монгол Улсын Их Хурал, Засгийн Газар, Улсын Онцгой Комисс, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн сайдаас ирсэн үүрэг даалгаврыг шуурхай хангана**
- ✓ **Эрүүл мэнд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268, А/387/99 тушаалуудын хэрэгжилтүүлнэ**
- ✓ Даатгуулагчдад болон гэрээт байгууллагад халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн ажиллахыг уриална
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангийн Эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлнэ

1.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- ✓ Даатгуулагчийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэнэ

- ✓ Эрүүл мэндийн байгууллагуудад тусламж, үйлчилгээний чанарыг эрхэмлэх гэрээлэлт хийж, хэрэгжилтийг хангаж буйд тогтмол хяналт тавина
 - ✓ Даатгуулагчдад эрүүл мэндийн салбарын хууль эрх зүй, санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна
 - ✓ Олон улсын эмнэлзүйн удирдамжийн UpToDate платформын ашиглалтыг сайжруулна
- 1.2.4 Даатгуулагчдыг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.
- ✓ Урьдчилан сэргийлэх үзлэгийн багц үзлэгт хамрагдах даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ
 - ✓ “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг санхүүжүүлнэ
 - ✓ “Эрүүл шүд Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг Эрүүл мэндийн яамнаас ирсэн чиглэлийн дагуу зохион байгуулна

1.3 Эрүүл мэндийн даатгалын орлого тооцолтын шимтгэлийн хувь

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх шимтгэлийн хувийг тооцохдоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн заалт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үндэслэн дараах байдлаар төлөвлөсөн.

- Хөдөлмөр, нийгмийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420,000 төгрөгийг хэвээр байхаар тооцсон.
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.1-д заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар тооцсон.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхэд болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.12-т заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 4,200 /дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгөөр (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420 000 төгрөгийн 1%-иар) тооцсон.
- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтны эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 8400 /найман мянга дөрвөн зуу/ төгрөгөөр (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420 000 төгрөгөөс 2%-иар) тооцсон.

1.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тооцооллын зарчим

1.4.1 Орлогын тооцоолол

- Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх, ажиллагсдаас төлөх, төсөвт байгууллагаас төлөх, сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогыг тооцохдоо Нийгмийн

хамгаалал, хөдөлмөрийн яамнаас ирүүлсэн нийт цалингийн орлогын төлөвлөгөөнд үндэслэн гаргасан.

- Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 472 дугаар тогтоол, 2020 оны 75 дугаар тогтоолыг өөрчлөлтгүйгээр тооцсон.
- Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг Үндэсний Статистикийн Хорооны “Статистикийн нэгдсэн мэдээллийн сан – 1212.mn”-аас гаргасан 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, хүүхдээ 2 /ихэр бол 3 / нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтан зэрэг зорилтот бүлгийн тоог 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлд үндэслэн гаргасан тоотой харьцуулан тооцсон.
- 2022 оны төсвийн төсөлд “Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл”-ийн орлогод 2017-2020 оны хооронд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлтөөс үүссэн авлагын дүнг нэмж оруулаагүй боловч 2021 онд уг орлогыг хүлээгдэж буй гүйцэтгэлээр нь тооцсон.

1.3.2 Зарлагын тооцоолол

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ, оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жин, журмыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна. Дээрх тогтоолын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тариф шинэчлэгдсэн бөгөөд 2022 онд төлбөрийн хэмжээнд өөрчлөлт орохгүйгээр тооцож, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллын төсвийг батлагдсан орны тоо, орны эргэлт, 2021 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, ЭМДС-аас нэхэмжилж буй оношийн бүлгийн дундаж зардал, эрүүл мэндийн байгууллагын ирүүлсэн саналыг тус тус үндэслэн төсөвлөсөн.
- 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу хувийн хэвшлийн үүдэн эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах болсон тул төсвийг 2022 онд нэмэгдүүлсэн.
- Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 04 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн аргад үндэслэн төсвийг нэмэгдүүлсэн.
- Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг 2021 оны эхний 07 сарын гүйцэтгэлд үндэслэн тооцож нэмэгдүүлсэн.
- Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн зардлыг тухайн тусламж, үйлчилгээг хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд үндэслэн хүртээмжийг сайжруулах зорилгоор нэмэгдүүлсэн.

- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1, 2.1.2 дох заалтуудад тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр, “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөр, “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээ” арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлнэ гэж тооцсон.
- Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.1, 1.1.2.2 дох заалтуудын дагуу дэлхий нийтийг хамарч буй “Ковид-19” цар тахлын эсрэг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба зөвхөн хэвтэн эмчлүүлэх болон ПГУ шинжилгээний тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцна гэж тооцсон.
- ЭМДҮЗ, ЭМДЕГ-ийн үйл ажиллагааны зардлыг ажиллах бүтэц, орон тоо, үйл ажиллагааны хамрах хүрээнд уялдуулан тооцсон.
- Хөрөнгө оруулалтын зардлыг 2021 оны батлагдсан төсвөөс бууруулсан.
- Эрсдэлийн сангийн хөрөнгийг сангийн шимтгэлийн орлогын 8 хувиас хэтрүүлэлгүй тооцсон.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН 2021 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд сангийн нийт орлого 951.3 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг 344.2 тэрбум төгрөгөөр (36.2 хувь) нэмэгдэж **1,295.5 тэрбум** төгрөгөөр тооцоолсон.

Монгол улсад үүсээд буй Коронавирус халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын улмаас Эрүүл мэнд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268, А/387/99 тушаалуудын дагуу хэвтэн эмчлүүлэх, гэрийн хяналт, дархлаажуулалтын үйл ажиллагаа, тандалтын дагуу хийгдэх ПГУ шинжилгээ зэрэг тусламж, үйлчилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Уг тусламж, үйлчилгээний санхүүжилт 2021 оны батлагдсан төсөвт тусгагдаагүй байсан тул тодотгон авахаар тооцсон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон шимтгэлийн хувиар тооцсон “Төр даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл”-ийн орлого 2021 оны батлагдсан төсөв болох 84.1 тэрбум төгрөгөөс гүйцэтгэл нь давж буй тул төсвийн тодотголд саналаа өгнө гэж тооцсон.

Харин сангийн нийт зарлага 1,210,703.3 сая төгрөгөөр батлагдсан ба хүлээгдэж буй гүйцэтгэл 240.5 тэрбум төгрөгөөр (19.9 хувь) давж 1,451.3 тэрбум төгрөг болно гэж тооцсон. Шалтгаан нь хууль эрхзүйн шинэчлэл, ковид-19 цар тахлын эсрэг үйл ажиллагаатай хамааралтай. Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээнд 260.2 тэрбум төгрөг зарцуулна гэж тооцсон.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцэл /сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2021 оны төсөв		
		Батлагдсан төсөв	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Өсөлт /хэмнэлт/
А. ОРЛОГО		951,266.5	1,295,486.6	344,220.1
1	Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	133,598.5	133,598.5	0.0
2	Даатгуулагчийн төлөх шимтгэл	158,202.3	158,202.3	0.0
3	Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	47,816.9	47,816.9	0.0
4	Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл	84,128.5	168,154.0	84,025.5
5	Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	19,425.8	19,425.8	0.0
6	Бусад орлого	11,629.3	11,629.3	0.0
7	Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	496,465.2	496,465.2	0.0
8	Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээ		260,194.6	260,194.6

Б. ЗАРЛАГА		1,210,703.3	1,451,248.2	(240,544.9)
1	Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний зардал	607,762.6	607,762.6	0.0
2	Бусад яамны харьяа эрүүл мэндийн байгууллагын зардал	20,950.6	31,006.1	(10,055.5)
3	Хувийн эмнэлгээр үйлчлүүлэх даатгуулагчийн зардал	102,920.4	159,093.1	(56,172.7)
4	Анхан шатлалын тусламж, үйлчилгээний зардал	219,809.0	219,809.0	0.0
5	Эмийн хөнгөлөлтийн зардал	65,000.0	79,612.7	(14,612.7)
6	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний зардал	7,000.0	7,000.0	0.0
7	Засгийн газрын хөтөлбөр арга хэмжээний зардал	18,000.0	9,625.6	8,374.5
8	Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээ	0.0	260,194.6	(260,194.6)
9	Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ	0.0	0.0	0.0
10	ЭМД-ын тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан даатгалын гэрээтэй ЭМБ-д олгох урамшууллын зардал;	800.0	800.0	0.0
11	Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал	1,100.0	1,100.0	0.0
12	Үйл ажиллагааны зардал/ЭМДҮЗ, ЭМДЕГ/	14,764.7	14,764.7	0.0
13	Хөрөнгө оруулалтын зардал	132,116.0	40,000.0	92,116.0
14	Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт, бусад	480.0	480.0	0.0
15	Эрсдэлийн сангийн хөрөнгө	20,000.0	20,000.0	0.0
САНГИЙН ТЭНЦЭЛ		(259,436.8)	(155,761.7)	103,675.2

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны батлагдсан төсөв болон хүлээгдэж буй гүйцэтгэл

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

3.1 Сангийн 2022 оны төсвийн тэнцэл

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн төсөлд сангийн орлогыг 1,545.7 тэрбум төгрөгөөр, сангийн зарлагыг 1,696.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөв. Энэ нь 2021 оны батлагдсан төсвөөс орлого 594.4 тэрбум төгрөгөөр (62.5%), зарлага 485,8 тэрбум төгрөгөөр (40.1%) нэмэгдэж байна. Эргэн төлөх төлбөрийн хэмжээг ЭМДҮЗ-ийн 2021 оны 06 дугаар тогтоолоор өр төлбөрт суутган авсан хөрөнгийн дүн болон 2021 оны эхний 07 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн дансанд төлөгдсөн төлбөрийн нийт дүнг хасагдуулан тооцож 2022 онд 90.8 тэрбум төгрөг байхаар тооцсон.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл /сая төгрөгөөр/

	САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2020	2021		2022
		Гүйцэтгэл	Батлагдсан	ХБГ	Төсөл
1	А. ОРЛОГО	486,120.3	951,266.5	1,295,486.6	1,545,656.8
2	Б. ЗАРЛАГА	426,384.4	1,210,703.3	1,451,248.2	1,696,519.8
	Зөрүү	59,735.9	(259,436.8)	(155,777.5)	(150,863.0)
3	ЭРГЭН ТӨЛӨХ ТӨЛБӨР	0	136,400.0	45,600.0	90,800.0

2020 оны гүйцэтгэл, 2021 оны батлагдсан төсөв болон хүлээгдэж буй гүйцэтгэл, 2022 оны төсвийн төсөл

3.2 Сангийн орлого

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн төсөлд нийт 1,545.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 401.2 тэрбум төгрөгийг ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлогоос, 168,2 тэрбум төгрөгийг төр хариуцах иргэдийн шимтгэлийн орлогоос, 19.8 тэрбум төгрөгийг шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлогоос, 740.5 тэрбум төгрөгийг төр хариуцах тусламж, үйлчилгээний улсын төсвийн орлого, 210.7 тэрбум төгрөгийг Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээнд зориулсан орлогоос бүрдүүлэхээр тус тус төлөвлөв.

Нийт төлөвлөсөн орлого 2021 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 591.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба 134,3 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 457.5 тэрбум төгрөгийг улсын төсвийн эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 3. Сангийн нийт орлого /сая төгрөгөөр/

	2021 оны төсөв	2022 оны төсвийн төсөл		Эх үүсвэр	
		Төлөвлөгөө	Зөрүү	ЭМД	Улсын төсөв

НИЙТ ОРЛОГО		951,266.5	1,545,656.8	591,782.3	134,334.0	460,040.4
1	Аж ахуйн нэгж, байгууллагын олгогчийн төлөх шимтгэл	133,598.5	154,442.6	20,844.1	20,844.1	
2	Даатгуулагчийн төлөх шимтгэл	158,202.3	187,145.5	28,943.2	28,943.2	
3	Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	47,816.9	59,594.9	11,778.0	11,778.0	
4	Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл	84,144.4	168,154.0	84,009.6	84,009.6	
5	Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	19,425.8	19,814.3	388.5	388.5	
6	Бусад орлого	11,629.3		(11,629.3)	(11,629.3)	
7	Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	496,449.3	740,521.1	241,479.7		241,479.67
8	Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээ		215,968.6	215,968.6		215,968.62

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2022 оны төсвийн төсөл болон өнгөрсөн оноос өссөн дүн, нэмэлт орлогыг санхүүжүүлэх эх үүсвэр

Нийт орлогыг эх үүсвэрээр нь авч үзвэл 48 хувийг эрүүл мэндийн тухай хуулийн дагуу төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох татаас, 14 хувь нь “Ковид-19” цар тахлын эсрэг арга хэмжээ, 26 хувийг хөдөлмөр эрхэлж буй даатгуулагчдын шимтгэл, 11 хувийг төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл эзэлж байна.

Зураг 1. 2022 оны нийт орлого /эх үүсвэр/



3.3 Сангийн зарлага

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн төсөлд нийт 1,696.5 тэрбум төгрөгийн зарлага гарахаас 799.4 тэрбум төгрөгийг лавлагаа шатлалын улсын эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардалд, 252.2 тэрбум төгрөгийг хувийн эмнэлгээр үйлчлүүлэх даатгуулагчийн зардалд, 222.4 тэрбум төгрөгийг анхан шатлалын тусламж, үйлчилгээний зардалд, 87.1 тэрбум төгрөгийг эмийн хөнгөлөлтийн зардалд, 20.0 тэрбум төгрөгийг Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний зардалд, 41.6 тэрбум төгрөгийг Засгийн газрын хөтөлбөр арга хэмжээний зардалд, 216.0 тэрбум төгрөгийг “Ковид-19” цар тахлын эсрэг арга хэмжээний зардалд, 14.8 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 7.8 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд, 20.0 тэрбум төгрөгийг эрсдэлийн санд тус тус зарцуулахаар төлөвлөв.

Нийт төлөвлөсөн зарлага нь 2021 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 465.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба 25.8 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сантай хамааралтай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, 460.0 тэрбум төгрөгийг төр хариуцах тусламж үйлчилгээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 4. Сангийн нийт зарлага /сая төгрөгөөр/


	2021 оны төсөв	2022 оны төсвийн төсөл		Эх үүсвэр	
		Төлөвлөгөө	Зөрүү	ЭМД	Улсын төсөв
НИЙТ ЗАРЛАГА	1,210,703.3	1,691,277.8	480,574.5	25,776.1	454,798.4

1	Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний зардал	607,762.6	754,450.7	146,688.1	21,495.9	125,192.2
2	Бусад яамны харьяа эрүүл мэндийн байгууллагын зардал	20,950.6	44,981.9	24,031.3	12,496.3	11,535.0
3	Хувийн эмнэлгээр үйлчлүүлэх даатгуулагчийн зардал	102,920.4	252,167.6	149,247.1	88,135.6	66,353.4
4	Анхан шатлалын тусламж, үйлчилгээний зардал	219,809.0	222,401.0	2,592.1	-	2,592.1
5	Эмийн хөнгөлөлтийн зардал	65,000.0	87,130.4	22,130.4	7,306.2	14,824.2
6	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний зардал	7,000.0	20,000.0	13,000.0	13,000.0	
7	Засгийн газрын хөтөлбөр арга хэмжээний зардал	18,000.0	41,574.8	23,574.8	-	23,574.8
8	Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээ	0.0	210,726.7	210,726.7	-	210,726.7
9	ЭМБ-д олгох урамшууллын зардалд	800.0	800.0	-		
10	Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд	1,100.0	1,100.0	-		
11	Үйл ажиллагааны зардал /ЭМДҮЗ, ЭМДЕГ/	14,764.7	14,764.7	-		
12	Хөрөнгө оруулалтын зардал	132,116.0	700.0	(131,416.0)	(131,416.0)	
13	Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт, бусад	480.0	480.0	-		
14	Эрсдэлийн сангийн хөрөнгө	20,000.0	40,000.0		20,000.0	

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2022 оны төсвийн төсөл болон өнгөрсөн оноос өссөн дүн, нэмэлт орлогыг санхүүжүүлэх эх үүсвэр

Нийт зардалд эзэлж буй тусламж, үйлчилгээний нэр төрлөөр авч үзвэл 45 хувийг Эрүүл мэндийн яамны харьяа лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд, 15 хувийг хувийн эрүүл мэндийн байгууллагад, 13 хувийг анхан шатны тусламж, үйлчилгээнд, 12 хувийг “Ковид-19” цар тахлын эсрэг тусламж, үйлчилгээнд, 6 хувийг эмийн хөнгөлөлтөд, 3 хувийг бусад яамны харьяа эмнэлгүүдэд, 5 хувийг бусад тусламж, үйлчилгээнд олгохоор төлөвлөж байна.

Зураг 2. Нийт зардал /тусламж, үйлчилгээний төрлөөр/



Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зардал эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлтэй холбоотой огцом өсч байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу зарим тусламж, үйлчилгээний тариф өссөн, даатгуулагчаас авах төлбөртэй тусламж, үйлчилгээний нэр төрлийг бууруулсан, эрхтэн шилжүүлэн суулгах хагалгаа, өндөр өртөгт оношлогоо шинжилгээг даатгалын сангаас санхүүжүүлэх болсон, “Ковид-19” цар тахлын эсрэг арга хэмжээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байгаа зэрэг шалтгаанаар нийт зардлын 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2022 оны төсвийн төсөлд нэмэгдүүлэн тооцсон.


Зураг 2. Нийт зардлын өсөлт




2021 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 2022 оны төсвийн төсөлд нэмэгдэж буй зардлууд.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн даатгалын санд зардал нь дутагдалтай байгаа жирэмсний хяналт, хорт хавдрын бай, туяа, химийн эмчилгээ, эрхтэн шилжүүлэн суулгах өндөр өртөгт мэс засал, өндөр өртөгт мэс засал, MRI, CT, судсан дотуур хийх оношлогоо, дуран зэрэг өндөр өртөгтэй оношлогоо, гэмтлийн яаралтай тусламж, уламжлалт, сэргээн засах эмчилгээ, “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөр, төр хариуцах эмийн зардал, эмийн үнийн хөнгөлөлт зэрэг тусламж үйлчилгээний төсвийг нэмэгдүүлэн холбогдох судалгааг төсвийн төсөлд хавсаргав.


Зураг 3. Лавлагаа шатлалын ЭМЯ-ны харьяа эмнэлгийн төсөв



Зураг 4. Бусад эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтэд



Зураг 5. Хөнгөлөлттэй эмийн зардал



Зураг 6. “Ковид-19” цар тахлын эсрэг арга хэмжээний зардал



3.4 Сангийн хөрөнгө оруулалт

Эрүүл мэндийн даатгалын сангаас хийх хөрөнгө оруулалтын 2022 оны төсвийн саналд нийт 0.7 тэрбум төгрөгийн өртөгтэй туулах чадвар сайн том оврын суудлын 2 ширхэг автомашин худалдан авахаар тусгасан. Үндэслэл нь эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт аргагүйгээр дэмжин ажиллахад шаардлагатай албан томилолт, зарим яаралтай тусламж, үйлчилгээний дэмжлэг, судалгаа шинжилгээ болон бусад албаны ажилд шаардлагатай тээврийн хэрэгслүүд юм. Эдгээр нь "Алсын хараа-2050", "Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2021-2024"-ийн зарим заалтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий хөрөнгө оруулалт юм.